



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/17

Баян-Өндөр сум

**Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны
бүтэц, орон тоог батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 487 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны бүтэц, орон тоог хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан бүтэц, орон тоог мөрдөн ажиллахыг Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба (Д.Сайзмаа)-нд үүрэг болгосугай.

3.Энэ захирамж батлагдсантай холбогдуулан "Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны бүтэц, орон тоог батлах тухай" аймгийн Засаг даргын 2024 оны А/315 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЗОРИГТБАЯР

Аймгийн Засаг даргын 2025 оны
01 дүгээр сарын 10 -ны өдрийн
117 дугаар захирамжийн хавсралт

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН
АЛБАНЫ БҮТЭЦ, ОРОН ТОО

| д/д | Ажлын байр буюу албан тушаалын нэр | Орон тоо | Тайлбар |
|-----|--|-----------|-------------|
| 1 | Албаны дарга буюу Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч | 1 | ТЗ-4 |
| 2 | Ахлах мэргэжилтэн, Дотоод аудитор-Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, (СХШУАБ) | 1 | ТЗ-7,(ТЗ-6) |
| 3 | Дотоод аудитор-Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч | 2 | ТЗ-6 |
| 4 | Дотоод аудитор-Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч | 4 | ТЗ-7 |
| 5 | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн | 1 | ТЗ-9 |
| 6 | Нягтлан бодогч | 1 | ТҮМ-6 |
| 7 | Архив, бичиг хэргийн эрхлэгч | 1 | ТҮМ-3 |
| 8 | Нярав | 1 | ТҮ-4 |
| | НИЙТ ОРОН ТОО | 12 | |